


Хатуу сэтгэлт түшмэл Уучлал өршөөл цуцлагдах боломжтой

“Хэрэв би хүнийг уучлахгүй бол Ертөнцийн Эзэн намайг ч уучлахгүй, зөв үү?” гэж нэгэн пастораас хүн асуулаа. Пастор тойруулан олон үг хэлсний эцэст өнөө хүн асуултаа давтахад



пастор “тийм ээ” гэж хэлэхээс өөр аргагүй мэт хүлээн зөвшөөрөв. Энэ хариу тэр пасторт хэцүү байсан нь ил. Библид бичсэнчлэн Бүтээгч Эзэний хайр ивээл хязгааргүй билээ. Харин Түүний уучлал өршөөл бидний уучлах чадвараар хязгаарлагддаг гэсэн санаа үүнтэй нэг л авцалдахгүй.

Гэтэл Их Эзэн Есүс Өөрөө яалт ч үгүй тийм санаатай үгийг хэлсэн. Үүнд:

“Хэрэв та нар хүмүүсийн алдааг уучилбал (G863) тэнгэрлэг Эцэг чинь та нарыг мөн уучилна (G863). Харин та нар хүмүүсийг эс уучилбал (G863) Эцэг чинь мөн алдааг чинь эс уучилна (G863).” (Матай 6:14-15)

Петр ийн уучлахын хязгаарыг мэдэхийг хүсээд Есүс хандан: “Эзэн, ах дүү маань миний эсрэг нүгэл үйлдэхэд би хэдэн удаа уучлах (G863) вэ? Долоон удаа юу?” гэж асуухад Есүс хариуд нь: “Би чамд долоон удаа бус, харин дал дахин долоон удаа гэж хэлье.” (Матай 18:21-22)

Тэгээд Их Эзэн үгээ тодруулж батлахын тулд Петрт дараах сургаалт зүйрлэлийг ярьсан (Матай 18:23-35):

23 Тэнгэрийн хаанчлал нь зарц нартайгаа тооцоо хийхийг хүссэн нэгэн хаантай адил юм.

24 Тэр тооцоо хийж эхлэх үед арван мянган талантын өртэй нэгнийг түүн дээр аваачив.

25 Харин түүнд төлөх юм байхгүй тул эзэн нь

түүнийг эхнэр, хүүхдүүдийнх нь хамт хамаг юмтай нь худалдаад өрийг нь барагдуулахыг тушаажээ.

26 Зарц сөхрөн унаж түүнд мөргөөд "Эзэн, намайг тэвчиж хүлцэнэ үү. Би танд бүгдийг төлнө" гэж гуйхад

27 тэрхүү зарцын эзэн ихэд өрөвдөн түүнийг суллаж, өрийг нь хэлтрүүлжээ (G863).

28 Харин өнөөх зарц гадагш гараад, өөрт нь зуун денарын өртэй байсан анд болох нэгэн зарцыг олж хараад барьж авч хоолойг нь боож, "Өрөө төл" гэв.

29 Харин анд нь болох тэр зарц сөхрөн унаж, түүнээс гуйн "Намайг тэвчиж хүлцээч. Чамд бүгдийг төлнө" гэж хэлжээ. 30 Харин тэр үл хүссэн тул явж, түүнийг өр ширээ төлтөл нь шоронд хаяв.

31 Анд зарц нар нь болсон явдлыг хараад ихэд гутарч, эзэндээ очиж болсон бүгдийг мэдэгджээ.

32 Тэгтэл эзэн нь түүнийг дуудаад, түүнд "Ёрын муу зарц, чи надаас гуйсан тул би бүх өрийг чинь хэлтрүүлсэн (G863).



33 Би чамайг өршөөсний (грек: аварч энэрэх, G1653) адил чи бас анд чинь болох тэр зарцыг өршөөх (грек: аварч энэрэх, G1653) ёстой байсан бус уу?" гээд,

34 ихэд хилэгнэн уурлаж, өр ширээ бүгдийг нь төлөх хүртэл түүнийг зандалчинд тушаажээ.

35 Түүнчлэн та нарын хүн нэг бүр чинь ах дүүгээ зүрхнээсээ эс уучлах (G863) аваас тэнгэрлэг Эцэг минь ч та нарт мөн тэгж хандах болно гэлээ.”

Өршөөл үзүүлэх ба цуцлах нь хааны эрх

Энэ сургаалт үлгэрээс уучлал өршөөлийн мөн чанар тодоос тод харагддаг. Юуны өмнө уучлах, өршөөх гэсэн үгийн утгыг авч үзье.

- Ихэвчлэн “уучлах” гэж орчуулсан грек үг (G863) үндсээрээ “суллаж явуулах, орхих, тавих, өр хэлтрүүлэх, өршөөх, уучлах” гэсэн утгатай үг. Хүн бидний эсрэг гэм хийхдээ бидэнд нэг ёсондоо өртэй болдог. Тэр өрийг нь бид нэг бол нэхэж, нэг бол уучилж хэлтрүүлж болно. Уучлах нь хийснийг нь хийгээгүй мэт тооцон орхиж, гомдлоо тавьж, тэр хүнийг өрөөс нь чөлөөлж, тавин явуулахыг хэлнэ.

- Өршөөх гэдэг монгол үг дотроо хоёр янзын утга агуулдаг. Mongoltoli.mn-н дагуу “өршөөх” гэдэг нь нэг бол “зовж зүдэрсэн хүнд туслах, аварч энэрэх” гэсэн утгатай үг (33-р ишлэлд гарсан G1653 шиг), нэг бол “гэм зэмийг нэхэмжлэлгүй уучлан хэлтрүүлэх” гэсэн утгатай үг (уучлах буюу G863 шиг). Үүнчлэн “өршөөн хэлтрүүлэх” гэдэг нь “алдаа дутагдал, ял зэмийг нэхэн хэлэлцэлгүй уучлах” гэсэн үг.

“Уучлал өршөөл үзүүлэх” нь энэ сүүлчийн утгатай бөгөөд гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүнд үзүүлэх улс төрийн удирдагчийн онцгой эрх юм.

Wikipedia-д уучлал өршөөлийг энэ талаас сайн тайлбарласан учраас тэндээс иш татъя:



“Өршөөл үзүүлэх (хууль эрх зүйн ойлголт) гэдэг нь ялтанг оногдуулсан... ялаас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөх... дээд эрх мэдэл бүхий хуулийн этгээдийн (ихэвчлэн төрийн тэргүүн) үйлдэл юм. Өршөөлийн хуулиар урьд өмнө ял эдэлж байсан хүмүүсийн ял шийтгэлийг хасч болдог... Уучлал өршөөл бол төрийн эрх мэдэл, шударга ёсны тогтолцоотой нэгэн зэрэг бий болсон эрүүгийн хуулийн хамгийн эртний зүйлүүдийн нэг юм. Үүнийг олон мянган жилийн туршид Хаад өргөн хэрэглэж ирсэн.”

Яг энэ хаадын үйлдлийг Есүс Их Эзэн дээрх сургаалт зүйрлэлээрээ ярьсан.

Тэр хаан зарц нартайгаа тооцоо хийхээр болсон. Зарц нар нь улсын хэрэг дээр үйлчилж, өр хурааж болдог түшмэд нь байгаа бололтой. “Түмэн талант” бол грек хэлний илэрхийлж чадах хамгийн том тоо. Ганц талант ажилчин хүний арван тав гаран жилийн цалин хөлстэй дүйцэх учраас “түмэн талант” нь хэзээ ч төлж барахааргүй үлэмжийн их мөнгийг хэлнэ. Зарц нь өрөө яасан ч төлж чадахгүй нь тодорхой. Гэтэл зарц хааны өршөөл гуйсан буюу Монгол толийн үгээр “өөрийн буруугаа хүлээн зөвшөөрч, хаанаас аврал эрч, тус болохыг хүссэн” (mongoltoli.mn).

Төлнө гэсэн
амлалт нь
бодит бус
гэдгийг хаан
мэдээд
зарцаа
өрөвдөн,
тавьсан өрийг
нь нэгмөсөн
хүчингүй
болгосон.



Гэвч тэр зарц ийм их өршөөл хайрыг даан ч үнэлж чадсангүй нь. Удалгүй өөртөө өртэй бас нэгэн зарцыг олж, өрөө нэхээд зогсохгүй, шууд төлж чадаагүйд нь хүлээх ч үгүй, ямар ч өрөвч сэтгэл гаргалгүй түүнийг шууд шоронд хаясан. Уг нь тэр зарцын өр зуухан денар буюу зуун өдрийн цалин хөлстэй дүйцнэ. Түмэн талантын хажууд юу ч биш. Зарцынхаа харгис хатуу үйлдлийн тухай сонсохдоо хаан ихэд уурлан зэвүүцэж, тэр зарцад үзүүлсэн өршөөлөө тэр даруй цуцалжээ.

Үүнээс юуны өмнө ойлгох зүйл бол энэ: Уучлал өршөөл бол тэнсэн харгалзах зүйл. Хүнд өршөөл үзүүлж ялыг нь хэлтрүүлэхдээ хаан цаашид тэр хүнийг биеэ зөв авч явна гэсэн хүлээлттэй. Зан авираа засахгүй хүн өөрийгөө хааны уучлал өршөөлийг хүртэх ёсгүй хүн болохоо үзүүлнэ. Тийм хүнээс төрийн өршөөлийг эгүүлэн татах нь бас хааны эрх юм. Уучлал өршөөл тогтох нь өршөөл хүртсэн хүний биеэ авч явах байдлаас шалтгаална

гэсэн үг. Өршөөл цуцлуулсан хүн эргээд өртэй, буруутай өмнөх байр сууриндаа орж, өмнө нь тогтоогдсон ял шийтгэлээ эдлэх ёстой. Улс төрийн хувьд энэ нь ойлгомжтой.

Гэхдээ энэ ёс зарчим бас Ертөнцийн Эзэн ба хүний хоорондох харилцаанд үйлчилдэг гэж Есүс хэлсэн. Ертөнцийн Эзэн яг л тэр үлгэрийн хаан шиг бөгөөд уучлал өршөөл хүртсэн хүн



бусдыгаа уучлахгүй бол өршөөлөө цуцлах болно гэж Есүс дагалдагч нартаа ахин анхааруулсан.

Энэ бол үнэхээр цочирдмоор үг. Үнэхээр тийм гэж үү? “Христ Есүс дотор байгаа хүмүүст ямар ч ял үгүй” (Ром 8:1) зэрэг үгийг тэгвэл хэрхэн ойлгох ёстой вэ? Ертөнцийн Эзэний үгэнд багтсан ийм авралын баталгаа олон байдаг ч, энэ сургаалт зүйрлэл тэдгээр үгтэй нэг л авцалдахгүй. Харин Ертөнцийн Эзэний үг дотроо зөрчилдөөнгүй гэдгийг бид мэднэ. Учрыг нь олохын тулд энэ сургаалт зүйрлэлийн учрыг тайлцгаая.

Сургаалт зүйрлэлийн сонсогч, учир, сэдэв

Библийн ямар ч хэсгийн утгыг зөв тайлахын тулд хам сэдвийг нь мартаж болохгүй.

Есүс чухам хэнд, бас яагаад сургаалт зүйрлэл ярьдаг байсан бэ?

Энэ хоёр асуултыг Их Эзэн маань Өөрөө «Шинэ гэрээ»-нд анх удаа “сургаалт зүйрлэл” гэдэг үг гардаг «Матай» номын 13-р бүлэгт хариулсан. Тухайлбал:

“Түүн дээр үй олон
хүн хуран цугласан
тул Тэр завин дээр
гарч суужээ. Хурсан
олон цөм эрэг дээр
зогсож байлаа. Есүс
тэдэнд олон зүйлийг
сургаалт зүйрлэлээр
ярьж... Шавь нар Түүн
дээр ирж,



-Та яагаад тэдэнд
сургаалт зүйрлэлээр
ярьдаг юм бэ? гэхэд Тэр

-Тэнгэрийн хаанчлалын нууцуудыг мэдэх нь та нарт
өгөгдсөн юм. Харин тэдэнд өгөгдөөгүй...

Тэд харавч эс ухааран, сонсовч үл сонсдог агаад
ойлгодог ч үгүй тул Би тэдэнд сургаалт зүйрлэлээр
ярьдаг...” (Матай 13:2-3,11-13)

Есүс өмнө нь сургаал заасан ч энд анх удаа нууцлаг
утгатай сургаалт зүйрлэл ярьсан. Хэнд сургаалт
үлгэрээ ярьсан бэ гэвэл, Израилын энд тэндээс
цугласан олонд. Энэ хүмүүс өмнө нь Есүсийн
тодорхой үгээр заасан сургаалыг сонссон ч
ойлгосонгүй. Анх олон нийтийн өмнө гарахдаа Есүс:
“Гэмшицгээ! Тэнгэрийн хаанчлал ойрхон байна гэж
тунхаглаж эхлэв... (Матай 4:17,23-24).

Энэ бол «Хуучин гэрээ»-нд Израилд амласан тэнгэрийн хаант улс юм (“хаанчлал” гэж орчуулсан грек үг мөн “хаант улс” гэсэн утгатай). “Тэнгэрийн хаанчлал” гэсэн нэр томъёо тэр улсыг тэнгэрт байхыг хэлээгүй, харин “тэнгэрийн Бурхан”-ы байгуулах тэр хаант улс тэнгэрлэг мөн чанартай байх болохыг илэрхийлнэ. Энэ хаант улсыг “Дээдийн Дээд Бурханы ариун ард түмэн” болох үнэнч итгэлтэй израилынхан хүлээж авах болно (Даниел 2:44; 7:13-14,18). Энэ нь Израилын дуудлагын дагуу: “Та нар Миний тусгаар ариун үндэстэн, тахилчдын хаант улс байх болно” (Гэтлэл 19:6). Өөрөөр хэлбэл, тэд Ертөнцийн Эзэний хаант улсад өндөр тушаалтай зарц түшмэд нь болгон үйлчлэх дуудлагатай.

Үйлчлэлийнхээ эхэнд Есүс тэнгэрийн хаант улсыг зарлахдаа илэн далангүй ярьдаг байсан. Матай 5-7-д тэмдэглэсэн Есүсийн сургаалыг “уулан дээрх сургаал” гэдэг. Энэ сургаал бол Хаант улсын шинэчилсэн хуулийн тунхаг. Энэхүү тунхагт бас дээрх уучлах шаардлага орсон билээ (Матай 6:9-12, 14-15).



Израилын хүсэн хүлээсэн тэр Хаант улсыг ойртсон тухай сайн мэдээг Есүс тунхагладаг байв. Дээр нь янз бүрийн өвчинтэй хүмүүсийг эдгээсэн. «Хуучин гэрээ»-нд Ертөнцийн Эзэний тослон томилсон Машиах буюу Аврагч Хаан яг ийм гайхамшиг хийж, сайн мэдээг авчирна гэсэн зөгнөл бий. Үүний хоёр жишээг дурдахад:

“Намайг ИАВЭ тослон томилсон учраас
Над дээр Эзэн ИАВЭгийн сүнс байна.
Зүдэрсэн хүмүүст сайн мэдээг авчирч,
Шархалсан сэтгэлтэй хүмүүсийг эдгээхийн төлөө,
Олзлогдсонд нь эрх чөлөөг тунхаглаж,
Хүлээстэйг нь суллахын төлөө
Намайг Тэрбээр илгээсэн юм...” (Исаиа 61:1)

“Харж бай, Бурхан чинь өшөө
авахаар ирнэ.
Бурхан хариугаа амсуулахаар ирнэ.
Бас та нарыг аварна” гэж хэлэгтүн.
Тэгэхэд хараагүй хүний нүд
нээгдэж,
Сонсголгүй хүний чих онгойно.
Хазгар хүн буга мэт дүүлж,
Хэлгүй хүн баясан дуулна...”
(Исаиа 35:4-6)



Машиахыг таних эдгээр тэмдгийг Есүс ард түмэндээ хэдэн жилийн турш харуулда байв (Үйлс 2:22). Гэвч харамсалтай нь, Есүсийн хэлсэн үгийг сонссон ч, хийсэн гайхамшгуудыг нь харсан ч тэд Түүнийг

амласан Аврагч Хаан гэж таньсангүй. Тэдэнд “хаанчлалын нууцуудыг мэдэх нь өгөгдөөгүй” учраас тэр.

Үүнийг мэдээд Есүс цугласан олонд тодорхой үгээр юм заахаа больж, оронд нь сургаалт зүйрлэл ярьдаг болсон. Сургаалт зүйрлэлүүд нь тэдгээр нууцыг агуулсан ч ойлгох ёсгүй хүнээс халхалдаг. Хаанчлалын нууцуудыг мэдэх онцгой эрх хүртсэн дагалдагчиддаа л Есүс сургаалт үлгэрүүдээ тайлбарладаг байв.



“Тэнгэрийн хаанчлал нь зарц нартайгаа тооцоо хийхийг хүссэн нэгэн хаантай адил” гэж эхэлдэг хатуу сэтгэлт түшмэлийн тухай сургаалт зүйрлэл “Тэнгэрийн хаанчлал” буюу Ертөнцийн Эзэний энэ дэлхийд байгуулахаар амласан хаант улсын тухай нь лавтай. Тэгвэл тайлал нь ч гэсэн тус хаант улс ба тэр хаант улсад хэрхэн орох тухай болж таарна.

Хатуу сэтгэлт түшмэлийн учир

Асар их өртэй зарц гэж хэнийг хэлдэг вэ?

«Хуучин гэрээ»-ний дагуу израилчууд Ертөнцийн Эзэний зарц нар. Мөнхийн Эзэн хэлэхдээ:

“Израилчууд бол Миний зарц нар, Египет газраас гаргаж авчирсан зарц нар минь юм. Харин Би бол ИАВЭ, та нарын Бурхан” гэв (Хууль 25:55).

Тэгэхлээр Хааны зарц нар израилчууд буюу тэдний хэсэг болох иудейчүүдийг хэлнэ.

«Үйлс» номын үед амьдарсан иудейчүүд өөрийн

Машиах Аврагч

Хаанаа үл таниад

зогсохгүй, Түүнийг

загалмай дээр

цовдолж

алуулахад

хүргэсэн (Үйлс

2:23-37; 3:13-19;

4:27). Хаанаасаа

урвасан тэд

Ертөнцийн Эзэний өмнө хэмжээлшгүй их буруутай

болсон. Тэдэнд Хаант улсдаа орох ямар ч найдвар

үлдээгүй байв.



Гэтэл Ертөнцийн Эзэний Сүнсээр дүүрэн буй

апостол Петр иудейчүүдэд энэ байдлаас гарах ганц

гарцыг зааж өгсөн. Тухайлбал: “Гэмшигтүн, гэм

нүглээ уучлуулахын төлөө та нар цөм Есүс Христийн

нэрээр баптисм хүртэцгээ. Ингэснээр та нар Ариун

Сүнсийг бэлэг болгон авах болно” гэв (Үйлс 2:38)

“Гэмших” гэж орчуулсан грек үг “бодол санаагаа

өөрчлөх”-ийг хэлнэ. Тэр хүмүүс Есүс хэн болох тал

дээр бодол санаагаа өөрчилж, Түүнийг Машиах

Хаанаа гэж хүлээн зөвшөөрч, үүнийг батлуулахаар

усан баптисм хүртэх ёстой байв. Пентекостын өдөр

3000 орчим хүн Петрийн зөвлөлгөөг дагаж, баптисм

хүртсэн. Есүс Их Эзэн дэндүү агуу нинжин сэтгэлтэй

учраас энэ дэлхийд байгуулах Хаант улсын тэргүүний хувьд ард түмэндээ уучлал өршөөл үзүүлэх эрхээ тэр өдөр ашигласан. Ертөнцийн Эзэн тэднийг үнэхээр уучилж, авах ёстой шийтгэлийг нь хүчингүй болгосон. Тэдний Хаант улсад нь хааны зарц түшмэд байх байр суурь нь сэргээгдсэн. Сургаалт үлгэрийн өршөөл хүртсэн зарц энэ хүмүүсийг төлөөлнө. Тэд асар их өртэй боловч Хаан өрийг нь хэлтрүүлж, бурууг нь хэрэгсэхгүй болгож, шинэ боломжийг тэдэнд бэлэглэсэн.

Үүнээс харахад хатуу сэтгэлт түшмэл иудейчүүдийг бөгөөд ялангуяа Есүст итгэсэн иудейчүүдийг төлөөлнө. Тэд өнөө түшмэл шиг Есүс Хааны уучлал өршөөлийг гүйн авсан учраас тэр.

Хааны уучлал өршөөл тодорхой болзолтой билээ. Өршөөгдсөн хүн буруу бодлоо бүрэн засаж, биеэ цаашид зөв авч явах ёстой. Эс тэгвээс уучлал цуцлагдах болно. Есүсийн ялангуяа анхааруулсан зүйл бол энэ: Ертөнцийн Эзэний энэрлийг амссан хүн өөрөө ч бусдад энэрэнгүй хандах ёстой. Энэ тал дээр олон итгэгч иудейчүүд даан ч буруудсан. Тэд өөрсөддөө “бага өртэй” хүмүүст даан ч өршөөнгүй хандаж чадсангүй нь.

Бага өртэй зарц нь

Бага өртэй хүмүүс тэгвэл хэн бэ? Израилд Ертөнцийн Эзэн олон онцгой амлалт ба эрх дарх өгснөөс гадна Машиах Аврагчийг ч илгээсэн бол

бусад үндэстнүүдэд юу ч өгөөгүй. Тэдэнд Хаант улсыг лав амлаагүй. Тэдэнд Ертөнцийн Эзэний ямар ч Үг ба мэргэн ухаан байгаагүй. Тэгсэн ч гэсэн тэд Христийг цовдолсон иудейчүүдийг бодвол Түүний эсрэг бага гэм хийсэн хүмүүс. Ертөнцийн Эзэний тухай мэддэг зүйлээ тэд иудейчүүдээс мэдэж авсан учраас иудейчүүдэд тодорхой хэмжээний өртэй (Ром 15:27). Гэхдээ энэ өр иудейчүүдийн өрийн хажууд өчүүхэн. Өнөө зуун денарын өртэй хүн бусад үндэстнүүдийг төлөөлөх юм.

«Үйлс» номноос харахад Их Хааны уучлал өршөөл хүртсэн Израилын итгэгчид тэр хайр энэрлийг бусад үндэстний хүмүүстэй хуваалцах ямар ч бодолгүй байв. Есүсийн тухай гадаад хүнд ярьсан анхны еврей хүн Петр билээ. Харин Петрийг хүртэл Ертөнцийн Эзэн ром хүн болох Корнелын гэрт очихоор ятгахын тулд үзэгдэл үзүүлэх шаардлагатай байв.

Корнел аль хэдийн гэр бүлээрээ Ертөнцийн Эзэнээс эмээдэг, иудейчүүдэд их өглөг өгдөг, байнга Ертөнцийн Эзэнтэй ярьдаг хүн байв (Үйлс 10:1). Ийм сайн харь хүнийг ч иудейчүүд үздэггүй учраас

Петрийг гэрт нь очсоны дараа бусад итгэгч иудейчүүд дургүйцэн, “Та хозлуулаагүй эрчүүд дээр



очиж, тэдэнтэй хамт хооллосон гэж үү?” гэж түүнийг шүүмжлэв. Петр бүгдийг нь нэгд нэгэнгүй тайлбарлаж, тэр харь хүмүүс баптисм хийгээгүй байхад ч Ариун Сүнс тэдэн дээр буусныг онцлоод “Их Эзэн Есүс Христэд итгэсэн бидэнд өгсөн тэр адил бэлгийг Ертөнцийн Эзэн тэдэнд өгсөн бол Түүнд саад болох би хэн билээ?” гэж хэлсний дараа л тэд тайвшран, “Тэгвэл үндэстнүүдэд ч гэсэн Ертөнцийн Эзэн амь руу хөтлөх гэмшлийг соёрхсон юм байна” гэцгээв (Үйлс 11:2-18; МО).

Еврейжүүлэгч нарын бүлэг

Гэвч фарисайчуудын дундаас Есүст итгэсэн иудейчүүд, Паулын үйлчлэлээр итгэсэн харь хүмүүсийг заавал хозлуулж, Мосегийн хуулийг сахих ёстой гэж үзэв. Харийн нутгийг нь тэд зорьж очин, шаардлагаа тавьж эс тэгвээс аврагдах боломжгүй гэж итгэгчдийг үймүүлсэн. Энэ иудейчүүд Есүсийг Машиах Хаан гэж хүлээж авсан боловч Түүнийг зөвхөн Израилын Аврагч Эзэн гэж үзсэн. Иудей шашны үүд хаалгаар орохгүй бол аврагдахгүй гэж үзсэн тэр хүмүүсийг еврейжүүлэгч гэдэг. Хозлолын тухай үүсгэсэн багагүй маргааныг Иерусалим хотын чуулганы удирдагч нар эцэст нь шийдэн, үндэстний итгэгчид ганц хэдэн дүрмээс өөр Хуулийг ч дагах, хозлолын зан үйлийг ч хийлгэх шаардлагагүй гэсэн тогтоол бичиг гаргав (Үйлс 15).

Иудейжүүлэгч нар удирдлагын энэ шийдийг хүлээж авахаас өөр аргагүй ч гэсэн үзэл бодлоо өөрчлөөгүй.

Паулыг Их Эзэнтэй учирч, үндэстнүүдэд үйлчлэхээр томилсон апостол нь гэдэгт тэд итгээгүй, харин ч түүнийг буруу сургаал заадаг этгээд гэж үзэв (1 Коринт 9:1-6; Үйлс 21:21). Иймд тэд Паулыг үзэн ядаж, түүнийг хаа сайгүй гүтгэн, “биеэрээ доожоогүй дорой бөгөөд үг яриа нь ч үл тоогдохоор” гэж шүүмжлэн тохуурхаж, заадаг сургаалыг нь эсэргүүцэж, байгуулсан цуглааных нь итгэгч нарыг үймүүлдэг байв (2 Коринт 10:10; Галат 1:7, 5:10).

Паулыг сүүлчийн удаагаа Иерусалим хотод очихдоо Иерусалимын ядуу итгэгч нарт зориулж үндэстнүүдийн итгэгчдийн цуглуулсан хандив өглөгийг авчрав (Ром 15:25; Үйлс 24:17). Ингээд тэрээр нэг ёсондоо үндэстнүүдийн “өрийг дарах” алхам хийлээ. Иаков ба бусад чуулганы удирдагч нар түүнийг итгэлийн ах гэж баяр хөөртэйгээр угтан авч, Ертөнцийн Эзэн үндэстнүүдийн дунд юу юу хийснийг сонсоод Их Эзэнийг магтан хүндлэв. Тэгээд түүнд иудейчүүдийн дундаас “өчнөөн түмэн” хүн итгэгч болсон бөгөөд бүгд Мосегийн Хуулийн төлөө улаан зүтгэлтэн байдаг тухай бахархан ярив. Гэвч тэр хүмүүс бүгд Паулыг үндэстнүүдийн дунд буй иудейчүүдэд хозлуулах хэрэггүй, Мосегийн Хуулийг орхих ёстойг заадаг гэсэн худал мэдээллийг сонсоод итгэсэн учраас түүнийг хотод ирснийг сонсоод зэвүүцэн, үйл олноороо цугларах нь зайлшгүй гэж санаа зовов (Үйлс 21:20-22).¹

1 “Үйл олноороо цугларах нь зайлшгүй” гэсэн нь АБ-д байхгүй болохоос Синаитикус, Александринус зэрэг хуучны грек гар бичмэлд байгаа (Center for New Testament Restoration).

Ази аймгаас ирсэн зарим иудейчүүд Паулыг хараад танингуутаа түүнийг хаа сайгүй иудей ард түмний эсрэг, Ертөнцийн Эзэний хуулийн эсрэг, сүмийн өргөөний эсрэг ухуулан сурталдаж явдаг “нөгөө хүн байна” гэж хашгирч, Паулыг баривчлуулсан. Үүнд үнэхээр хот бүхэлдээ үймээнд автаж, хүмүүс гүйлдэн ирж, Паулыг алах гэж балбаж нүдэн бөөн шуугиан болсон. Энэ хүмүүсийн дунд мөнөөх Мосегийн Хуулийн төлөөх улаан зүтгэлтэн түмэн итгэгч нараас олон байсан нь гарцаагүй.

“Иерусалим хотынхон бослого гаргаж байна” гэж тэндхийн Ромын цэргийн ангийн захирагч сонсож, шууд цэргүүдийнхээ хамт очиж Паулыг баривчилж, алуулахаас нь аварсан. Тэгэхэд Паул ард түмэнд үг хэлэх зөвшөөрлийг цэргийн ангийн захирагчаас гуйн авав.

Ингээд “Бурханы төлөө зүтгэн” байж өөрийг нь алах шахсан тэр хүмүүст Паул еврей хэлээр өөрийгөө танилцуулж, хэрхэн Есүст итгэдэг хүмүүсийг үхэлд тушаалтал хавчиж байсан тухайгаа ярьсан. Тэгэж улайран явж байхдаа Есүс Их Эзэнтэй учирч, Түүнээс шинэ үүрэг авсан тухайгаа ярихыг нь тэд дуугүй сонссон. Харин “үндэстнүүд” гэсэн үгийг дөнгөж дурдахад нь тэд



үгийг нь цаашид сонсохоос татгалзаж, “Ийм хүнийг газрын хөрснөөс зайлуул! Тэр амьд явах ёсгүй!” гэж хашхиралдан, галзуу хүмүүс шиг аашлав (Үйлс 22:3,20-22; МО).

Бусад үндэстнүүдийг Ертөнцийн Эзэн байгаагаар нь буюу Израилын шашингүйгээр хүлээж авснаа Өөрийн томилсон ахлах апостол Петрт тов тодорхой харуулсан байхад ч иудейжүүлэгч итгэгч нар бусад

үндэстний итгэгчдийг байгаагаар нь хүлээж авахаас татгалзав.



Үүгээр ч зогсохгүй, үндэстнүүдэд илгээсэн Ертөнцийн Эзэний зарцыг тэд алж хядах гэж байсан. Өнөө бага өртэй зарц

Паулыг ч билэгдэх юм. Паул Есүсийн дагалдагч нарыг хавчснаар тэдэнд нэг ёсондоо өртэй болсон байв. Гэхдээ Паулын хийсэн хэрэг хичнээн аймшигтай ч гэсэн Машиах Аврагчийг хороохын хажууд бага.

Ямартай ч, Паул үндэстнүүдийн сүнслэг өрийг дарах гэж олон цуглаанд нь мөнгө цуглуулж, өөрийн биеэр урт замыг туулан байж тэр мөнгийг Иерусалимд авчрахдаа өөрийн өрөө ч төлөх төлбөр хийж байгаа гэж ойлгож болно. Гэвч бэлэг сэлттэй ирсэн ч гэсэн иудейжүүлэгч үзэлтэй итгэгч нар түүнд хатуу сэтгэлт түшмэлийн хайр найргүй хандлага гаргасан. Түүний Христтэй учирсанд тэд итгээгүй, Есүст итгэсэнд нь итгээгүй, Түүнээс томилолт авсанд нь итгээгүй,

үндэстнүүдэд заадаг сургаалыг нь үнэн зөв гэдэгт бүр ч итгээгүй.

Иудейчүүдийн харгисаар довтолсноос болж Паул ромчуудад баривчлагдаад зогсоогүй, хоёр жил шоронд байсны эцэст тэдэнд алуулах аюул замхраагүй байв. Иймд Паул Ромын эзэн хаанд давж заалдахыг хүсээд Ром хотод шилжиж, тэнд ч хоригдов (Үйлс 24:27, 25:11).

Хааныхаа бусад зарц нарт ийм өршөөлгүй, хатуу сэтгэл гаргасны төлөө Ертөнцийн Эзэн тэдэнд хүртээсэн уучлалыг цуцалсан буй за. Их Хааныхаа хүлээж авсан хүмүүст энэрэнгүй сэтгэлээр хандаагүй тухайн иудей итгэгчид Хаант улсад нь орох эрхээ хасуулсан гэсэн үг. Уучлал өршөөл нь өршөөгдсөн хүний биеэ авч явах байдлаас шалтгаалах, тэнсэн харгалзах зүйл учраас тэр.

Христийн Бие болох бид өршөөл хүртсэн биш, зөвтгөсөн хүмүүс

Паулын тунхагласан сайн мэдээнд итгэсэн бидэнд энэ сургаалт үлгэр шууд хамаагүй. Машиах Хааны байгуулах хаант улс энэ дэлхийн эзэнт гүрний засаг төрийг устган орлуулах бодит хаант улс байх болно. Харин биднийг Ертөнцийн Эзэн одоо ч “хайрт Хүүгийнхээ Хаант улсад шилжүүлсэн”. “Хүүгийнх нь дотор бидэнд нүглийн уучлал болох зоилт байна” (Колоссай 1:13-14).



Бодит хаант улсын энэ дүрслэлээр Паул сүнслэг үнэнийг илэрхийлсэн. Үүнд: Бид өнөөдөр амьдарч буй улс орныхоо төрийн эрх мэдлийн дор байгаа хэвээр ч төрийг эрхшээлдээ байлгадаг Харанхуйн хүчнээс аврагдсан. Уучлал өршөөл үзүүлэх нь зайлшгүй хаант улстай холбоотой учраас Паул Хаант улсын дүрслэлд нийцэхээр биднийг “уучлал” өршөөл авсан гэж бичсэн.

Харин яг хэлэхэд Ертөнцийн Эзэн бидэнд үүнээс ч илүүг өгсөн. Тэр уучлахаас ч илүү биднийг харин зөвтгөн зөвт тооцсон. Ертөнцийн Эзэн биднийг Христийн цусаар ямар ч гэм буруугаас цагаатгасан (Ром 3:24). Цагаатгах юмуу зөвтгөх гэдэг нь шүүхийн хэрэг юм. Шүүхэд буруутгагдсан хүнийг нэг бол яллах, нэг бол цагаатгах нь шүүгчийн үүрэг. Гэтэл шүүгч уучлал өршөөл үзүүлж болдоггүй. Бид Израилын хаант улсад үйлчлэх дуудлагагүй, харин Христийн үхэгсдээс амилахдаа эхлүүлсэн шинэ бүтээлд одоо ч хамрагдахад дуудагдсан. Паул итгэгчдийг хэзээ ч “Ертөнцийн Эзэний зарч нар” гэдэггүй, харин биднийг “Ертөнцийн Эзэний хүү нар” болохыг хэлсэн.²

2 Жишээ нь, Галат 4:6-7,31. Үүнийг Илчлэл 1:1,6-тай харьцуулаарай: “Удахгүй болох ёстой юмсыг боолууддаа үзүүлэхийн тулд Бурханаас Түүнд өгсөн, Есүс Христийн илчлэл....

Биднийг... хаанчлал төдийгүй, Бурхан ба Эцэгийнхээ төлөөх тахилч нар болгосон Түүнд алдар хийгээд ноёрхол нь үеэс үед байх болтугай. Амен.”

Энд “боол” гэж орчуулсан үг сургаалт үлгэрт маань “зарц” гэж орчуулсан үгтэй адилхан. Есүс Христ боолуудаа “хаанчлал” ба “тахилч нар” болгосон нь Израилын эртний дуудлагын дагуу (Гэтлэл 19:6). «Илчлэл» ном израилыханд зориулж бичигдсэн гэсэн үг.



Энэ байр сууринд орохын тулд бид сүнсний хувьд аль хэдийн Израилын мянган жилийн Хаант улсын дараа болох агуу их шүүхэд оржээ.

Ертөнцийн Их Шүүгч Христтэй нэгдсэн биднийг шүүн зөвтгөсөн учраас бидний эсрэг ямар ч буруутгал үлдээгүй. Бид Ертөнцийн Эзэний хувьд ямар ч “өргүй” хүмүүс гэсэн үг. Зөвтгөл маань бидний биеэ авч явах байдлаас шалтгаалахгүй, харин зуун хувь Христийн цусан дээр үндэслэдэг. Христийн цус хэзээд үнэт ба хүчтэй учраас Ертөнцийн Эзэний зөвтгөл тогтоол хэзээ ч цуцлагдахгүй. Зөвтгөл биднийг буруутгалын хүрээнээс нэгмөсөн гаргасан. Зөвтгөл тэнсэн харгалзах зүйл биш гэсэн үг. Тийм ч учраас Паул “Христ Есүс дотор байгаа хүмүүст ямар ч ял үгүй” гэж бичсэн (Ром 8:1).

Уучлал өршөөл

Хааны эрх
Израилаас гаралтай зарц нарт
нь зориулсан
уучлал гуйсан хүнд үзүүлдэг

тэнсэн чанартай
өрөвдсөний үр дүн
тогтох нь уучлагдсан хүний
үйлсээс шалтгаална
Уучлагдсан хүн бусдыг
уучлах ёстой.

цуцлагдах боломжтой!!

Зөвтгөл

Шүүгчийн үүрэг
Христ дотор хүү нь байх
дуудлагатай хүнд зориулсан
дуудагдсан хүнийг “үйлсгүй”
зөвтгөдөг

ямар ч болзолгүй
цэвэр хайр ивээлийн үр дүн
Христийн загалмайд үндэслэсэн
учраас тогтоно
Зөвтгөгдсөн хүн бусдад хайр
ивээлээр хандах уриалгатай.

цуцлагдах боломжгүй!!

Хэрэв хатуу сэтгэлт түшмэлийн тухай сургаалт зүйрлэл биднийг хэлээгүй бол уучлах шаардлагыг нь бид хэрхэн үзэх вэ? Иудейчүүдэд хэлсэн Есүсийн үгийг бид лав өөртөө наалдуулах хэрэггүй. Хэрэв бид хүнийг уучилж чадаагүй бол ер бусын Эцэг маань биднийг уучлахгүй гэж айгаад байх хэрэггүй. Үүнийг оршилдоо ярьсан пастор ойлгосон бол өөр хариу өгөх байсан.

Бусдад хайр ивээлээр хандах нь

Сонирхолтой нь, үндэстнүүдэд бичсэн Паулын захидлуудад “уучлах” гэсэн грек үйл үг «Хуучин гэрээ»-нээс иш татан ганц удаа гардаг болохоос өөр хаана ч гардаггүй (Ром 4:7). Уучлах ёстой гэсэн шаардлагыг хаанаас ч олохгүй. Иудей бус бид хүнийг уучлах хэрэггүй гэсэн үг үү? Мэдээж үгүй. Харин ч Есүсийн Петрт хэлсэн “дал дахин долоон удаа”-гаас хамаагүй ихийг биднээс хүссэн үгийг Паул хэрэглэсэн. Үүнд: “Нэг нэгэндээ элэгсэг сайхан хандан, энэрэн өрөвдөж, Ертөнцийн Эзэн та нарт Христ дотор хайр ивээлээр хандсаны (G5483) адил бие биедээ ч хайр ивээлээр хандаж (G5483) байгтун!” (Эфэс 4:32, грек эхийн дагуу орчуулав). “Хайр ивээлээр хандах” гэж орчуулсан үгийг (G5483) АБ энд “уучлах” гэж орчуулсан ч хатуу сэтгэлт зарцын тухай сургаалт үлгэрт орсон “уучлах өршөөх” (G836) гэсэн грек үгнээс өөр бөгөөд тэс өөр ойлголтыг агуулна. “Хайр ивээлээр хандах” гэдэг нь “харамгүйгээр, өгөөмрөөр өгөх, тэнүүн уудам, уужим сэтгэлээр ивээх, хайр хишиг үзүүлэх” гэсэн утгатай.

Үүнд уучлал багтах нь мэдээж. Гэхдээ уучлахаас хамаагүй илүү их зүйлийг хэлнэ.

Хайр ивээлийн нэг чухал, уучлал өршөөлөөс өөр чанар бол энэ: Хайр ивээл хүртэх хүн тэр хайрыг, тэр ивээлийг

хэрхэвч
авмааргүй
нэгэн
байдаг!!

Улмаар, бид
Ертөнцийн
Эзэний хайр
ивээлийг
хүртэхийн
тулд бусдад
хайр

Хайр ивээлээр
хандахын эсрэг
ойлголт юу вэ?



...үл тоох, бодлогогүй хандах,
гомдоох, зөрчилдөх,
дүргүйцэн эсэргүүцэх, өөрийн
эрх ашгаа л бодох...



ивээлээр хандах шаардлагатай биш. Харин бид аль хэдийн Их Эзэний хэмжээлшгүй их хайр ивээлийг авсан учраас уучлал хүртэх ёсгүй хүнд хүртэл хайр ивээлээр хандах уриалгатай.

Дүгнэж хэлэхэд, Есүсийн иудейчүүдэд заасан сургаал ба сургаалт зүйрлэлүүд хожим энэ дэлхийд байгуулах Хаант улсынх нь тухай. Тэр Хаант улсад орж төрд үйлчлэх амлалтыг эрт дээр үеэс авсан израилчууд тийш орохын тулд тодорхой шаардлагыг хангах ёстой. Есүсийн хэд хэдэн удаа дурдсан шаардлага нь бусдыг уучилж, энэрэнгүй ханддаг байхад оршино. Шаарлаганд хүрэхгүй бол Хаант улсаас хасагдана. Тийм хүн “өр ширээ бүгдийг нь төлөх хүртлээ” хэцүү байдалд байх болно (энэ

талаар мөн Үйлс 5:1-11; 2 Петр 2:21; Еврей 6:4-6; 10:26-31-г уншина уу).

Мэдээж иудейчүүд хэзээ ч Христийн эсрэг хийсэн хэмжигдэшгүй их буруугаа засаж чадахгүй. Харин Есүс загалмай дээр бүх хүн төрөлхтөний өрийг өмнөөс нь төлсөн. Алуурчдын үйлийг Ертөнцийн Эзэн эргүүлэн засан Түүнийг үхлээс амилуулсан. Цаг нь ирэхэд тэд үүнийг ойлгож, хүлээн авах бөгөөд “өр” нь ч гэсэн бүрэн төлөгдсөнд тооцогдох болно.

Бидэнд Ертөнцийн Эзэн Христийн Загалмайн үнэнд итгэх итгэлийг өнөөдөр ч өгч, биднийг “Христ дотор” оруулсан. Бид Хааны түшмэд биш, харин Биеийнх нь гишүүд. Түүнтэй бид салшгүй холбогдсон.

“Бид итгэмжгүй байлаа ч, Тэр итгэмжит хэвээр байна. Учир нь Тэр Өөрийгөө үгүйсгэж чадахгүй” (2 Тимот 2:13). Үнэхээр “Христ Есүс дотор байгаа хүмүүст ямар ч ял үгүй” (Ром 8:1).

Их Эзэнээ сэтгэлийн гүнээс талархан магтъя! □

Ашигласан эх сурвалж:

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичвэр Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Шинэ гэрээ»-ний ишлэлийг 2019 оны орчуулгаас авсан байх болно.

---Barnes, A. (1870). *Albert Barnes' Notes on the Bible*. As found in the [MySword Bible study software program](#)

---Библи (2015). Улаанбаатар : Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.

---Center for New Testament Restoration (2023). Collation. <https://greekcntr.org/collation/index.htm>

- Монгол хэлний их тайлбар толь. (2016). mongoltoli.mn
- Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Хуучин гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.
- Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org